



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/526

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэчийг сонгох,  
тендер хүчингүй болгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 93 дугаар дүгнэлтийн дагуу Багийн хөгжил, төрийн үйлчилгээ төсөл (Өвөрхангай, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Уянга, Хархорин, Хужирт сум) ажлын 2 дугаар багц 3 багийн өвсний фонд барих (Уянга, Хархорин) ажлыг 38850215 (гучин найман сая найман зуун тавин мянга хоёр зуун арван тав) төгрөгөөр Эм Би Би Импекс ХХК, 3 дугаар багц Багийн төвийн тоног төхөөрөмжийн шинэчлэл (Зүүнбаян-Улаан, Хужирт, Бат-Өлзий, Хархорин, Уянга) ажлыг 98000000 (ерэн найман сая) төгрөгөөр Арвайхээр өргөө ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т тус тус даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

4. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 1 дүгээр багц Багийн эмч нарыг унаажуулах (Зүүнбаян-Улаан) 4 дүгээр багц Багийн төвийн барилгын засвар, өргөтгөл (Зүүнбаян-Улаан, Хужирт, Бат-Өлзий, Хархорин, Уянга), 5 дугаар багц Багийн хүний нөөцийн чадавхыг сайжруулах (Зүүнбаян-Улаан, Хужирт, Бат-Өлзий, Хархорин) ажлуудыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцуудыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100930